



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

*“ТӨРИЙН САНГИЙН ТОГТОЛЦОО, ХУУЛЬ ТОГТООМЖИЙН
НИЙЦЭЛ” НИЙЦЛИЙН АУДИТ*


*ТӨРИЙН САНГИЙН ТОГТОЛЦОО БҮРДСЭН 4 ХОЛБОГДОХ
ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.*

ᠬᠡᠨᠲᠢᠶᠢ ᠠᠶᠢᠮᠠᠭ ᠳᠠᠬᠤ ᠲᠦᠷᠢᠶᠢᠨ ᠠᠤᠳᠢᠲᠤᠨ ᠭᠠᠰᠠᠷ



БҮЛЭГ 1. ТӨРИЙН САНГИЙН ТОГТОЛЦОО ОНОВЧТОЙ БҮРДСЭН БАЙНА.

1.1. Холбогдох хууль тогтоомжтой нийцүүлэн баталсан төрийн сангийн үйл ажиллагааны эрх зүйн актыг мөрдөн ажиллаж байна.



Төсвийн тухай хуулийн 36, 37, 38 дугаар зүйл


Төсвийн тухай хуулийн 37 дугаар зүйл, Засгийн газрын 2014 оны 326 дугаар тогтоол, Сангийн сайдын 2025 оны 90 дүгээр тушаал, 2024 оны 255, 256 дугаар тушаалууд

Төсвийн тухай хуулийн 37 дугаар зүйл, Засгийн газрын 2014 оны 326 дугаар тогтоол, Сангийн сайдын 2015 оны 90 дүгээр тушаал, 2024 оны 255, 256 дугаар тушаалууд



- Төрийн сангийн цахим мэдээллийн систем <https://finance.gov.mn/>
- Татварын нэгдсэн систем <https://etax.mta.mn/>
- Цалингийн нэгдсэн систем <https://payroll.ts.gov.mn/>
- Багцын гүйлгээ ts-pay.mof.gov.mn/
- Засгийн газрын газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн систем Freebalance/
- Цахим санхүүгийн тайлангийн систем <https://ebalance.mof.gov.mn/>

- Зөвшөөрлийн цахим систем license.frc.mn/
- Шагналын систем reward.mof.gov.mn/
- Санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн систем Finperform.mof.gov.mn/
- Төсвийн хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн систем bps.mof.gov.mn/
- Төсвийн төлөвлөлтийн цахим систем <https://fiscal.mof.gov.mn/>
- Е-хууль <https://ehuulga.mof.gov.mn/>

1.2. Төрийн сангийн зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх зохистой бүтэц бүрдсэн ч хүний нөөц тогтворгүй байна.



Сул орон тооны албан тушаалыг түр орлон гүйцэтгэсэн байдал



Биндэр сумын төсөв, төрийн сангийн мэргэжилтэн нь санхүүгийн албаны даргын ажлыг түр орлон гүйцэтгэж байгаа нь Сангийн сайдын 2024 оны 255 дугаар тушаалаар баталсан "Төрийн сангийн цахим системийн заавар"-ын 2.7, 256 дугаар тушаалаар баталсан "Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн систем мөрдөх заавар"-ын 6.9 дэх хэсэгт заасантай нийцэхгүй байна.




БҮЛЭГ 2. ТӨРИЙН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД МӨРДӨГДӨХ ХУУЛЬ ТОГТООМЖ, ЭРХ ЗҮЙН АКТЫН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

2.1. Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрх олголт нь батлагдсан төсвийн хүрээнд хэрэгжсэн боловч журамд заасан хугацаа, баталгаажуулах маягт, баримтжуулалтын шаардлагыг хангаагүй байна.

Улсын төсвөөс аймагт олгох санхүүгийн дэмжлэгийн талаар


Аймгаас сумдад олгох санхүүгийн дэмжлэгийн талаар



Санхүү, төрийн сангийн хэлтсээс нь сумдад олгох санхүүгийн дэмжлэгийг журамд заасан хугацаанаас ажлын 1-12 өдрөөр хоцроож олгосон нь Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 2.6.1-т заасан хугацааг зөрчсөн байна.


Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлгийн талаар

Сумаас аймагт төвлөрүүлэх орлогын талаар



Хэрлэн сумын Засаг дарга, Санхүүгийн албаны дарга нь аймгийн ИТХ-ын тогтоолоор батлагдсан сумаас аймагт төвлөрүүлэх орлогыг төсөвт төвлөрүүлэхдээ аймгийн Засаг даргын баталсан хуваарийг баримтлаагүй хугацаа хоцроож төвлөрүүлсэн байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар орон нутгийн төсвийн санхүүжилттэй холбоотой илэрсэн зөрчил




Аудитаар түүвэрт хамрагдсан сумдаас Баянхутаг, Мөрөн, Гурванбаян, Өмнөдэлгэр сумд тус журмын хавсралт маягтуудыг хөтлөн баримтжуулаагүй, төсөв захирагчаар хянуулалгүйгээр санхүүжилтийг олгосон байна.





2.2. Төрийн сангийн нэгдсэн данс, төлбөр тооцооны үйл ажиллагаа нь хууль, журмын дагуу баталгаажиг байгаа боловч зориулалт бус зарцуулсан, зардлын эдийн засгийн ангилал зөрүүлсэн зөрчилтэй гүйлгээг баталгаажуулсаар байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар бэлэн мөнгө зарцуулахтай холбоотойгоор эд хариуцагчийн дансанд шилжүүлж зарцуулсан




Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 3.6.1-т "Төсвийн байгууллага нь Төсвийн тухай хуулийн 35.6-д заасан санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Монголбанкттай хамтран баталсан журмын дагуу бэлэн мөнгө зарцуулах зориулалттай картын данстай байж болно.", 3.6.4-т "Төсвийн байгууллага төрийн сангаас тухайн байгууллагын дотоод үйл ажиллагааны хэрэгцээ шаардлагад нийцүүлэн баталж өгсөн хязгаарын хүрээнд жижиг мөнгөн сантай байж болно" гэсэн заалтуудыг зөрчсөн.

Төсвийг зориулалт бус зарцуулсан, батлагдсан төсвийн эдийн засгийн ангиллыг зөрүүлсэн, бүрдэл дутуу анхан шатны баримтаар гүйлгээ хийсэн зөрчил



Сангийн сайдын 2016 оны 431 дүгээр тушаалаар батлагдсан "Төрийн сангийн төлбөр тооцоо гүйцэтгэхэд үндэслэх баримт бичгийн жишиг, заавар"-ыг зөрчсөн.





"Төрийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 3.5.8-д "Төрийн сан нь сар бүрийн эцсийн ажлын өдөр 14 цагт зарлагын гүйлгээг хаана" гэсэн заалтыг зөрчсөн.



Үнийн дүн алдаатай, бэлтгэн нийлүүлэгч давхар бүртгэгдсэн, дансны дугаар бүртгэлгүй, кодын блонкын данстай тохирохгүй байх, төсвийн багц хүрэлцэхгүй, харилцагчийн данс мэдээлэл алдаатай

Анхан шатны баримт дутуу, төлбөрийн хүсэлтийн дүн анхан шатны баримтын дүнгээс зөрүүтэй, төрийн сангийн ажилтан батлахгүй 72 цаг болсон, төсөө хүрэлцэхгүй, хөтөлбөр, зориулалт, эдийн засгийн ангилал буруу




"Төрийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 3.4.21-т "Төсвийн байгууллага орлогын хуулгыг өдөр тутам хянаж, тодорхой бус орлогын талаар нягталж, орлого бууруулах гүйлгээг гаргахдаа холбогдох нотлох баримт болон орлогын дэлгэрэнгүй хуулгыг төлбөрийн хүсэлтийн хамт хавсаргаж ажлын 3 өдрийн дотор төрийн санд мэдэгдэн залруулах хүсэлт гаргана" гэснийг зөрчсөн.

2.3. Төрийн сангийн үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан дотоод хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлэхгүй байна.

Төрийн сангийн нэгжийн эрсдэлийн түвшний үнэлгээ



Дотоод хянал хэрэгжүүлсэн байдал



Дотоод хяналтаар илэрсэн зөрчлийн ангилал


д/д	Дотоод үйл ажиллагааны хяналтын чиглэл	Зөвлөмж авсан сумдын тоо
1	6.1.2. Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийг "Төрийн сангийн үйл ажиллагааны журам"-ын хоёрдугаар бүлэгт заасны дагуу олгож байгаа эсэх;	4
2	6.1.4. Төсвийн гүйцэтгэлийн мэдээг "Төрийн сангийн үйл ажиллагааны журам"-ын дөрөвдүгээр бүлэгт заасны дагуу нэгтгэн боловсруулсан эсэх;	4
3	6.1.6. Эрхийн бүртгэлийн сан систем дэх баримт бичгийн иж бүрдлийг цаасан суурьт гарын үсгийн баталгааны маягтай тулгах;	11
4	6.1.7. Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн систем, Төрийн сангийн удирдлагын цахим системд хийгдсэн гүйлгээнд хяналт хэрэгжүүлэх;	1
5	6.1.8. Тухайн төрийн санд хийгдсэн гүйлгээний баримт болон гүйлгээ хийхтэй холбоотой баримт материалыг цахим болон цаасан архивын нэгжийг иж бүрэн үүсгэж, харьяалах архивын байгууллагад хүлээлгэж өгсөн эсэхийг хянах;	12
6	6.1.9. Төрийн сангийн системийн хэрэглэгчийн эрхийг "Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн системд мөрдөх заавар"-т заасан маягтын дагуу шилжүүлсэн эсэхийг хянах;	3

1. Сумдын Санхүүгийн албанаас ирүүлсэн үнэлгээгээр эрсдэлгүй үнэлэгдсэн арга хэмжээ нь Санхүү, төрийн сангийн хэлтсээс хийсэн дотоод хяналтын дүнгээр зөрчил илэрч эрсдэлтэй гэж үнэлэгдэж байгаа нь эрсдэлийн үнэлгээг бодитой хийхгүй, эрсдэлд суурилсан дотоод хяналтыг хэрэгжүүлээгүйтэй холбоотой байна.

2. Төрийн сангийн үйл ажиллагааны өдөр тутмын дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй, дотоод хяналтын тайланд тусгаагүй байна.

АУДИТЫН ҮР ДҮНД ИЛЭРСЭН ЗӨРЧИЛД ӨГСӨН ШИЙДВЭР

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга-д:



Үндэсний аудитын газарт хүргүүлэх санал:

Санал 1

Төрийн сангийн удирдлагын цахим системээр зөрчилтэй гүйлгээг хянаж баталсан эрх бүхий албан хаагчид хариуцлага ногдуулах талаар журамд нэмэлт оруулах;

Санал 2

"Төрийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 3.5.8-д заасан сарын сүүлийн ажлын өдрийн 14 цагаас хойш гүйлгээ хийхгүйгээр Төрийн сангийн удирдлагын цахим системтэй уялдуулах;

Санал 3

"Төрийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 3.4.21 дэх хэсгийг зөрчсөн албан хаагчид хүлээлгэх хариуцлагын талаар журамд нэмэлт оруулах;

Санал 4

Нэг албан тушаалтанд гүйлгээг хянах болон батлах эрхийг давхардуулан олгохгүйн тулд тухайн орон тоо нөхөгдөх хүртэл хугацаагаар аймгийн төрийн сангийн холбогдох албан тушаалтанд түр шилжүүлдэг байх зохицуулалтыг "Төрийн сангийн цахим системийн заавар"-т нэмэлт өөрчлөлт оруулах